

2 0 2 6

СӨҮЛ ИХ СУРГУУЛИЙН ЭМНЭЛГИЙН ХАРЪЯА КАННАМ ТӨВ

ГАДААД ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨТӨЛБӨР



СӨҮЛ ИХ СУРГУУЛИЙН ЭМНЭЛЭГ

Эрхэм зорилго



Нарийн мэргэшсэн
эмч, ажилтан



Өвчтөнд
тохирсон үйлчилгээ




Мэдээллийн
нууцлал



Аюулгүй
байдал

НЭТВОРК



СӨҮЛ ИХ СУРГУУЛИЙН ХАРЪЯА ЭМНЭЛЭГ- КАННАМ ТӨВИЙН 'ОЛОН УЛСЫН ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ'

Гадаад иргэдэд үйлчлэх төв

- Нарийн мэргэжлийн тасаг
 - Дотор
 - Харшил
 - Зүрх судасны эмгэг судлалын тасаг
 - Дотоод шүүрлийн булчирхайн эмгэг судлалын тасаг
 - Хоол боловсруулах эрхтний эмгэг судлалын тасаг
 - Эх барих, эмэгтэйчүүдийн тасаг
 - Радиологийн тасаг
 - Лаборатори

- Гадаад хэлний орчуулгын үйлчилгээ
 - Англи
 - Орос
 - Хятад

Үйлчилгээ

- Нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө
- Хөтөч үйлчилгээ(Ярианы орчуулга, бичиг баримт гаргах, concierge зэрэг)
- Сөүл Их Сургуулийн эмнэлэгийн олон улсын багтай холбож өгөх
- Гадаад иргэдэд зөвлөгөө өгдөг байгууллагатай холбох
- Ойролцоох зочид буудлуудад хөнгөлөлт үзүүлэх

Эрүүл мэндийн үзлэг шинжилгээний багц хөтөлбөрүүд



Суурь хөтөлбөр

Суурь хөтөлбөр нь эрүүл мэндийн байдлыг шалгаж, аливаа өвчнийг анхан шатанд нь оношлох багц шинжилгээнээс бүрдэнэ.



Премиум хөтөлбөр

Премиум(дээд зэрэглэлийн) хөтөлбөрөөр дамжуулан хорт хавдар болон дотор эрхтний эмгэг өөрчлөлтийг анхан шатанд нь оношлоход томограф болон MRI-г хамгийн өргөн ашигладаг.



Нарийн мэргэжлийн үзлэгийн хөтөлбөр

Эрчимжүүлсэн хөтөлбөр нь хамгийн элбэг тохиолддог удамшлын өвчин болон тодорхой эрхтэн, өвчний цогц үзлэг үйлчилгээ үзүүлэхэд чиглэдэг.



Тусгай үзлэг шинжилгээ

Багц хөтөлбөр дээр тусгай хөтөлбөрийг нэмж үйлчлүүлэгчийн биеийн байдлыг илүү өргөн хэмжээний оношлогоо шинжилгээнд хамруулан аливаа өвчнийг анхан шатанд нь илрүүлнэ.

- ♦ Багц хөтөлбөрийн дүрс оношилгооны зураг(СD-ны хуулбар), эмчийн бичиг гаргаж өгнө.
- ♦ Ходоодны дуран шинжилгээг 84, бүдүүн гэдэсний дуран шинжилгээг 75-с доош насныханд хийнэ.
- ♦ 0.7 см-с дээш хэмжээтэй(судсанд тархсан, өргөсөж наалдсан) ургацгийг авахад хүндрэл үүсэх эрсдэлтэй тул авахыг хойшлуулна (биопсийн шинжилгээ хийж болно).

Суурь хөтөлбөр

Бүх багц хөтөлбөрт орсон шинжилгээнүүд : Эмчийн зөвлөгөө, ахуйн зуршлын үнэлгээ, биеийн ерөнхий хэмжилт, даралт, зүрхний бичлэг, уушигны үйл ажиллагаа, цээжний рентген зураг, унтуулгатай ходоодны дуран шинжилгээ, хэвлийн хөндийн эхо, цусны шинжилгээ(чихрийн шижин, гиперлипидеми, элэгний үйл ажиллагаа, бөөрний үйл ажиллагаа, цус багадалт, бамбай булчирхайн үйлажиллагаа Гепатит (А/В/С төрөл), Хеликобактер пилори эсрэгбие, Хавдрын маркер (Нойр булчирхай, элэг, бүдүүн гэдэс)], Шээсний шинжилгээ, хараа, нүдний даралт

Хөтөлбөр	Хамрагдах нас	Төлбөр(эр)	Төлбөр(эм)	Шинжилгээ
 Суурь хөтөлбөр	34≥	\$980	\$1,060	· Эмэгтэйчүүд : Эмэгтэйчүүдийн эмчийн үзлэг, зөвлөгөө, өндгөвчний хорт хавдар, умайн хүзүүний эсийн буюу цитологи шинжилгээ(PAP)
	≥35	\$1,020	\$1,140	· Ерөнхий : Нүдний рентген оношилгоо ♦ 50-с дээш насныхан : Сонсголын шинжилгээнд хамрагдана, А гепатитын шинжилгээ орохгүй. · Эрэгтэйчүүд : Түрүү булчирхайн хавдрын шинжилгээ · Эмэгтэйчүүд : Эмэгтэйчүүдийн үзлэг/зөвлөгөө, өндгөвчний хорт хавдрын маркер, умайн хүзүүний эс, хөхний рентген оношилгоо

Нарийн мэргэжлийн үзлэгийн хөтөлбөр

Нарийн мэргэжлийн үзлэгийн хөтөлбөрт багтсан шинжилгээ : Суурь хөтөлбөр + Нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө, шүдний үзлэг/рентген оношилгоо, Д витамин, А гепатитын шинжилгээ

Хөтөлбөр	Хамрагдах нас	Төлбөр(эр)	Төлбөр(эм)	Шинжилгээ
 Хорт хавдар	Бүх нас	\$2,970	\$2,920	· Ерөнхий : Мэдээгүйжүүлэгчтэй бүдүүн гэдэсний дуран шинжилгээ, хэвлий аарцагны СТ, Цээжний хөндий(уушиг)-н СТ, бамбай булчирхайн эхо, цусан дахь pepsinogen-ийн агуулга, цусны бүлэгнэл · Эрэгтэйчүүд : Төвөнхийн дуран шинжилгээ, шээсний котинин, элэгний хатуурал, түрүү булчирхайн MRI · Эмэгтэйчүүд : Эмэгтэйчүүд&хөхний эхо, хүний папиллома вирусын шинжилгээ(HPV), хөхний 3D рентген оношлогоо, ясны нягтрал
 Тархи	Бүх нас	\$2,400	\$2,530	· Ерөнхий : Тархины MRI/MRA(Үүнд гүрээний тараагуур судас багтана.)
 Зүрх, судас	Бүх нас	\$2,410	\$2,540	· Ерөнхий : Зүрх судасны 3D CT/Calcium scoring CT, ачаалалтай зүрхний цахилгаан бичлэг, зүрхний эхо, гүрээний тараагуур судасны эхо, микроальбумин, артерийн судасны хатуурал
 Хоол боловсруулах эрхтэн	Бүх нас	\$1,920	\$2,230	· Ерөнхий : Мэдээгүйжүүлэгчтэй бүдүүн гэдэсний дуран шинжилгээ, хэвлийн хөндийн СТ, цусан дахь pepsinogen-ийн агуулга, элэгний хатуурал, цусны бүлэгнэл · Эмэгтэйчүүд : Эмэгтэйчүүдийн эхо
 Уушиг	Бүх нас	\$1,940	.	· Эрэгтэйчүүд : Чих хамар хоолойн дуран шинжилгээ, Цээжний хөндий(уушиг)-н СТ, артерийн судасны хатуурал, шээсний котинин, гуурсан хоолойн багтраа(астма), амьсгалын хөдөлгөөн дэх азотын оксид
 Эмэгтэйчүүд	Бүх нас	.	\$2,200	· Эмэгтэйчүүд : Бамбай булчирхайн эхо, хөхний ба эмэгтэйчүүдийн эхо, хүний папиллома вирус(HPV), ясны нягтрал, эстрадиол дааврын шинжилгээ(4 төрөл)
 Эрэгтэйчүүд	Бүх нас	\$2,370	.	· Эрэгтэйчүүд : Түрүү булчирхайн MRI, Цээжний хөндий(уушиг)-н СТ, зүрх судасны 3D CT/Calcium Scoring CT



Премиум хөтөлбөр

Бүх премиум хөтөлбөрт орсон шинжилгээнүүд : Суурь хөтөлбөр + премиум зөвлөгөө, Хоол тэжээлийн заавар, шүдний үзлэг/рентген оношилгоо, сонсгол, цусны шинжилгээ(Д витамин, ревматод, 108 төрлийн харшлын оношилгоо, гиперлипидеми, пепсиноген, цусны бүлэгнэл), шээсний уураг, тархины MRI/MRA, гүрээний тараагуур судасны эхо, зүрхний эхо, ачаалалтай зүрхний цахилгаан бичлэг, артерийн судасны хатуурал, бамбай булчирхайн эхо, чих хамар хоолойн дуран шинжилгээ, цээжний хөндийн CT, хэвлий аарцагны CT, унтуулгатай бүдүүн гэдэсний дуран шинжилгээ

Хөтөлбөр	Хамрагдах нас	Төлбөр(эр)	Төлбөр(эм)	Шинжилгээ
 Премиум хөтөлбөр	35-49	\$5,210	\$5,590	· Эрэгтэйчүүд : Эстроген дааврын шинжилгээ, зүрх судасны 3D CT/Calcium scoring CT дүрс оношлогоо, элэгний фиброз(болон элэгний өөхжилт), шээсний котинин · Эмэгтэйчүүд : Эмэгтэйчүүдийн эхо, хүний папиллома вирус(HPV), эстрадиол дааврын шинжилгээ(4 төрөл), өндгөвчний хорт хавдрын шинжилгээ(HE4), бамбай булчирхайн цусны нарийн шинжилгээ, хөхний эхо, хөхний 3D рентген оношлогоо, нягтрал тогтоох шинжилгээ
	50-64	\$5,880	\$6,500	· Эрэгтэйчүүд : Премиум хөтөлбөр(35~49 нас) + Түрүү булчирхайн MRI, амьсгалын хөдөлгөөн дэх азотын оксид · Эмэгтэйчүүд : Премиум хөтөлбөр(35~49 нас) + Зүрх судасны 3D CT/Calcium scoring CT, хөхний MRI
	65-75	\$5,970	\$6,300	· Эрэгтэйчүүд : Премиум хөтөлбөр(50~64 нас) + Ясны нягтрал/Нуруу бүсэлхийн рентген оношлогоо · Эмэгтэйчүүд : Премиум хөтөлбөр(50~64 нас) + Нуруу бүсэлхийн рентген оношлогоо · Үүнд хүний папиллома вирус(HPV)-н болон эстрадиол дааврын шинжилгээ(4 төрөл) орохгүй.
	≥76	\$5,700	\$5,510	· Ерөнхий : Премиум хөтөлбөр(65~75 нас) · Үүнд бүдүүн гэдэсний дуран шинжилгээ орохгүй · Эмэгтэйчүүд : Премиум хөтөлбөр(65~75 нас) · Хөхний MRI орохгүй



Тусгай үзлэг шинжилгээ

♦ Тусгай хөтөлбөрт багтсан нарийн зөвлөгөөг мэргэжилтнүүд өгнө.
♦ Нэмэх боломжтой багц шинжилгээнүүд.

Ангилал	Хөтөлбөр	Төлбөр	Шинжилгээ	Ангилал	Хөтөлбөр	Төлбөр	Шинжилгээ
 Тархи	Тархины цус харвалт	\$1,954	Нарийн зөвлөгөө, тархины MRI/MRA(Үүнд гүрээний тараагуур судасны шинжилгээ багтана), зүрхний эхо, гүрээний тараагуур судасны эхо, микроальбумин, тархины харвалт оношлох цусны шинжилгээ	 Уушиг	Харшил	\$696	Нарийн зөвлөгөө, хамрын дайвар хөндийн рентген оношлогоо, хамар болон дайвар хөндийн дуран оношлогоо, гуурсан хоолойн багтраа(астма), харшлын арьсны сорил (52 төрөл. Шаардлагатай гэж үзвэл 108 төрлийн шинжилгээ хийх бөгөөд үүнийг дагаад үнэ нь өөрчлөгдөнө), амьсгалын хөдөлгөөн дэх азотын оксид
	Венийн судасны хэм алдагдал	\$653	Зөвлөгөө, зүрхний эхо, ачаалалтай зүрхний цахилгаан бичлэг, зүрхний 3 өдрийн тасралтгүй холтер бичлэг(MobiCare)		Архаг ханиалга	\$670	Нарийн зөвлөгөө, хамрын дайвар хөндийн дуран шинжилгээ болон рентген, төвөнхийн дуран шинжилгээ, Цээжний хөндий(уушиг)-н CT, гуурсан хоолойн багтраа(астма), шээсний котинин, Амьсгалын замын азотын оксид
	Ангина буюу зүрхний бах	\$837	Нарийн зөвлөгөө, ачаалалтай зүрхний цахилгаан бичлэг(тредмил тест), зүрх судасны 3D CT/ Calcium scoring CT, зүрхний эхо				

Ангилал	Хөтөлбөр	Төлбөр	Шинжилгээ	Ангилал	Хөтөлбөр	Төлбөр	Шинжилгээ
 Хоол боловсруулах эрхтэн	Smart Plus Гэдэсний дуран	\$600	Тайвшруулах үйлчилгээтэй Smart Plus Гэдэсний дуран ♦ Арилгасан полипийн тооноос хамаарч нэмэлт төлбөр төлнө.	 Тулгуур эрхтэн тогтолцоо	Хүзүү/ Бүсэлхий	\$1,290	Нарийн зөвлөгөө, хүзүү бүсэлхийн MRI, X-ray рентген дүрс оношлогоо
	Нойр булчирхайн MRI	\$939	Нойр булчирхайн MRI ♦ Тодосгогч бодис хэрэглэхэд 283 ам.долларын нэмэлт төлбөр авна.		Бүсэлхий нуруу	\$1,003	Нарийн зөвлөгөө, бүсэлхийн MRI, бүсэлхийн нарийвчилсан X-ray рентген дүрс оношлогоо
 Бөөр	Бөөр	\$641	Нарийн зөвлөгөө, бөөрний нарийвчилсан CT, микроальбумин, 24 цагийн шээсний шинжилгээ, шээсний хорт хавдрын эсийн шинжилгээ, цустай шээсний шинжилгээ, бөөрний хэвийн үйл ажиллагаа оношлох цусны нарийн шинжилгээ		Хүзүү	\$1,099	Нарийн зөвлөгөө, хүзүүний MRI, хүзүүний нарийвчилсан X-ray рентген дүрс оношлогоо
					Өвдөг	\$1,108	Нарийн зөвлөгөө, урьдчилсан үзлэг, өвдөг(нэг тал)MRI, өвдөг(хоёр тал) нарийвчилсан X-ray рентген дүрс оношлогоо
					Мөр	\$1,024	Нарийн зөвлөгөө, урьдчилсан үзлэг, мөр(нэг тал)MRI, мөрний(нэг тал) нарийвчилсан X-ray рентген дүрс оношлогоо
 Нүд	Нүд	\$399	Нүдний нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө, хараа, нүдний даралт тодорхойлох шинжилгээ, өргөн спектрийн рентген оношлогоо, оптик когерент томографи (OCT), нүдний эмгэг оношлох микроскоп симпламп шинжилгээ, гэрлийн хугарал		Ревматизм	\$96	Нарийн зөвлөгөө, ревматизмийн цусны нарийн шинжилгээ ♦ Эмчээс зөвлөгөө авсны дараа X-ray оношлогоо нэмж болно. Биеийн сегмент тус бүрд рентген оношлогооны нэмэлт төлбөр гарна (44USD). Заавал цусны шинжилгээ хийлгэнэ.
 Эмэгтэйчүүд	Эстрадиол дааврын шинжилгээ	\$145	Эстрадиол дааврын шинжилгээ 4 төрөл[LH, FSH, E2, AMH(Анти Мюллерийн даавар)] ♦ Хүсэлт гаргасан тохиолдолд нөхөн үржихүйн хадгалах үйлчилгээнд (жишээ нь, өндгөн эс хөлдөөх) шилжүүлэх зөвлөгөө авах боломжтой.	 Эрэгтэйчүүд	Түрүү булчирхайн томрол (Зөвхөн үдээс хойш)	\$368	Түрүү булчирхайн эхо, эстроген дааврын шинжилгээ, шээсний гарц тогтоох шинжилгээ, шээсний үлдэц тогтоох эхо шинжилгээ ♦ 13:00 цагаас хойш авна
	Гэрлэлтийн өмнөх үе (Эмэгтэйчүүд)	\$634	Эмэгтэйчүүдийн эхо, хөхний эхо, улаанууд(IgG, IgM), салхин цэцэг, эстрадиол дааврын шинжилгээ 4 төрөл[LH, FSH, E2, AMH(Анти Мюллерийн даавар)]				
	Эмэгтэйчүүдийн хураангуй MRI	\$482	Эмэгтэйчүүдийн үзлэг ба зөвлөгөө, эмэгтэйчүүдийн хураангуй MRI(тодосгогчгүй)		Түрүү булчирхайн хорт хавдар	\$642	Түрүү булчирхайн MRI, түрүү булчирхайн хорт хавдар илрүүлэх цусны дэлгэрэнгүй шинжилгээ
 Гадаад	Гадаад оюутан	\$467	Гадаад оюутнууд(виз)-д эрүүл мэндийн зөвлөгөө өгч, эмчийн тодорхойлолт гаргаж өгөхөөс гадна цус, A/B/C гепатит, улаан бурхан, гахай хавдар, улаанууд, салхин цэцэг, сүрьеэг нууц үед нь илрүүлэх, сүрьеэгийн арьсны сорил, Цээжний рентген, дүрс оношлогооны зургийн хуулбар гаргаж өгнө ♦ Шаардлагатай бол хамрагдах шинжилгээнд өөрчлөлт оруулна.	 Вакцин	Вакцин	Зөвлөгөө өгсний дараа нэмнэ.	A/B гепатит, улирлын чанартай томуу, хатгаа, салхин цэцэг, улаанууд, татран/сахуу/хөхүүл ханиад, умайн хүзүүний хорт хавдар, менингит, Бүслүүр үлд, балнад, япон энцефалит ♦ Заавал урьдчилан цаг авна : Балнад, япон энцефалит



Нэмэлт шинжилгээ

Ангилал	Хөтөлбөр	Төлбөр	Заавар	Ангилал	Хөтөлбөр	Төлбөр	Заавар
 Хоол боловсруулах эрхтэн	■ 0.7 см-с дээш хэмжээтэй(судсанд тархсан, өргөсөж наалдсан) ургацгийг авахад хүндрэл үүсэх эрсдэлтэй тул авахыг хойшлуулна(биопсийн шинжилгээ хийж болно) ■ Насны хязгаарлалт: Ходоодны дурангийн шинжилгээг 84-өөс доош насны хүмүүст хийх боломжтой 75-аас доош насны хүмүүст колоноскопи хийх боломжтой.			 Тархи	Гүрээний тараагуур судасны эхо	\$313	Гүрээний артери нь цусыг зүрхнээс тархи руу дамжуулдаг гол судас бөгөөд эхо шинжилгээгээр гүрээний судсаар дамжиж байгаа цусны урсгал, судасны үнэлгээг гаргаж, тархи руу орж байгаа цусны урсгалыг бууруулж байгаа шалтгааныг тодорхойлно.
	Мэдээгүйжүүлэгчтэй бүдүүн гэдэсний дуран шинжилгээ	\$449	Бүдүүн гэдэсний эмгэг өөрчлөлт(ургац, хавдар)-ийг оношлох дурангийн шинжилгээ.		Тархины MRI/MRA	\$1,222	Тархины эд, судасны эмгэг өөрчлөлтийг илрүүлэх MRI шинжилгээ ♦ Үүнд гүрээний тараагуур судас багтана.
	Хэвлийн хөндий, аарцагны CT	\$303	Элэг, дэлүү, бөөр, нойр булчирхай зэрэг хэвлийн хөндийн эрхтний эмгэг өөрчлөлтийг оношлох CT шинжилгээ	 Эмэгтэй	Эмэгтэйчүүдийн эхо	\$182	Умай, өндгөвч, умайн гуурсан хоолойн эмгэг өөрчлөлтийг оношлох шинжилгээ
 Амьсгалын замын эрхтэн	Цээжний хөндий(уушиг)-н CT	\$207	Уушигны хорт хавдар зэрэг цээжний хөндийн эрхтний эмгэг өөрчлөлтийг оношлох CT шинжилгээ		Эмэгтэйчүүдийн хураангуй MRI	\$482	Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрхтэн, аарцгийн эрхтнүүдийн MRI(тодосгогчгүй) ♦ Эмэгтэйчүүдийн үзлэг багтсан
 Зүрх	Ачаалалтай зүрхний цахилгаан бичлэг	\$108	Гүйлтийн зам дээр 10 минут орчим гүйх үед зүрхний эмгэгийн өөрчлөлтийг хянах (зүрхний шигдээс, стенокарди(ангина))		Хөхний эхо	\$217	Хөхний хортой, хоргүй хадвар оношлох эхо шинжилгээ
	Зүрхний эхо	\$293	Зүрхний бүтэц, үйл ажиллагааны эмгэг өөрчлөлтийг оношлох эхо шинжилгээ.		Хөхний MRI (тодосгогч бодистой)	\$618	Хөхний рентген оношлогоо, эхо шинжилгээгээр илрүүлэх боломжгүй хэсгийг нарийвчлан харах MRI шинжилгээ ♦ Үүнд хөхний ENT 3D рентген оношлогоо багтана.
	Calcium scoring CT /Зүрх судасны 3D CT	\$394	Зүрх судасны эмгэг өөрчлөлтийг оношлох CT шинжилгээ ♦ Үүнд микроалбумин багтана	 Эрэгтэй	Түрүү булчирхайн MRI	\$596	Түрүү булчирхайн хорт хавдрыг илрүүлэх MRI шинжилгээ
 Дотоод шүүрэл	Бамбай булчирхай эхо	\$202	Бамбай булчирхайн ургацыг оношлох эхо шинжилгээ		Түрүү булчирхайн эхо	\$232	Түрүү булчирхайн томрол, хорт хавдар болон бусад эмгэг өөрчлөлтийг илрүүлэх шулуун гэдэсний эхо шинжилгээ.
				 ENT	Чих, хамар, хоолойн дуран шинжилгээ	\$106	Чих хамар хоолойн эрхтэн системийн эмгэг өөрчлөлтийг оношилдог дуран шинжилгээ

Сөүл Их Сургуулийн Эмнэлгийн харъяа Каннам төв нь үйлчлүүлэгчийн өвчний намтар болон илэрч буй зовиур, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх аюултай хүчин зүйлийг харгалзан эрүүл мэндийн үзлэгт хамрагдах боломж бүхий багц хөтөлбөрүүдийг санал болгож байна.



Шинжилгээний цаг авах

· Утас: +82-2-2112-5500(Солонгос), +82-2-2112-5503(English) | Ажлын өдөр : 8:00-17:00
· Интернет: <http://mo-healthcare.snuh.org>



Шинжилгээний хариу, зөвлөгөө авах

· Шинжилгээний хариуг 5-7 хоногийн дотор нарийн мэргэжлийн эмч өгнө.
· Шаардлагатай үед хийх шаардлагатай үзлэг шинжилгээг даруй мэдэгдэнэ.
· Эмнэлэг дээр өөрийн биеэр ирж болон утас, вэб хуудсаар дамжуулан шинжилгээний хариуны дагуу зөвлөгөө авах боломжтой.
· Шинжилгээний хариугаар ямар нэгэн өвчний шинж тэмдэг илэрвэл нэмэлт зөвлөгөө өгнө.
· Утас: +82-2-2112-5601 | Факс: +82-2-2112-5590



Хаяг

· Хаяг: Өмнөд Солонгос, Сөүл хот, Каннам дүүрэг, Техран-ру 152(Ёгсам-дун 737) Каннам Файнанс төв 38-40 давхар
· Нисэх буудлын автобус : 6020 дугаарын автобус Инчон буудлаас Ёгсам буудал руу шууд явдаг(1 цаг 30 минут)
· Таксинд суувал жолоочид хаягаа үзүүлнэ үү:

→ 서울특별시 강남구 테헤란로 152 강남파이낸스센터



Вэб сайт



Зөвлөгөө авахыг хүсэх



Газрын зураг